



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/165

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга  
Гишүүдэд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Хүнс хөдөө аж ахуй газрын Мал үржлийн албаны дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн

-Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга

-Сайн засаглалыг дэмжигч төрийн бус байгууллага

-Иргэний нийгмийн байгууллага -Иргэн (Б.Аюуш-тохиролцсоноор)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дагуу олон нийтийн оролцоотой төлөвлөх ажлыг шуурхай зохион байгуулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэх ажлыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН